

## ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН ШИНЭТГЭЛ

Л. Лувсанжамц /Судлаач/, Б. Мөнхсоёл /Нээлттэй Нийгэм Форумын менежер/

### ЯАГААД ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ НЬ ЧУХАЛ ВЭ?

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төсөвт төвлөрч буй орлогын хэмжээ нэмэгдэж, орон нутгийн төсвийн орлогын Улсын нийт төсөвт болон ДНБ-д эзлэх хувь хэмжээ тасралтгүй буурч байна. Аливаа улс орны төвлөрсөн, эс төвлөрсөн байдлыг илтгэдэг гол үзүүлэлт нь улсын төсвийн орлого болон ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн орлого юм. (Зураг 1 -д үзүүлэв.)

Төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2000 онд 33,4 хувь байсан бол улмаар 2008 онд 43,7 хувь болон өсчээ. Харин орон нутгийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ эсрэгээр 2000 онд 6,5 хувь байснаа 2008 онд 2,8 хувь хүртэл буурсан байна. Орон нутгийн орлогын нийт орлогод эзлэх хувь мөн ижил динамикаар өөрчлөгджээ, 2000 онд 19,2 хувь байсан бол 2008 онд 6,4 хувь болтол буурсан байна.

*Зураг 1. Улсын ба орон нутгийн төсвийн орлогын  
ДНБ-д эзлэх хувь*



Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнуудын хувьд ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн зарлагын хувь дунджаар 10-15, төсвийн зарлагад эзлэх хувь дунджаар 20-25 байдаг. Үүнтэй харьцуулан үзэхэд Монгол Улсад санхүү, төсвийн төвлөрөл их байгаа нь харагдана.

Түүнчлэн орон нутгийн удирдлага, бодлого тодорхойлогчид, судлаачид 2002 онд батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төсөв салбарын яамд, агенлагт төвлөрч орон нутгийн төсөв хумигдаж, нутгийн удирдлагын байгууллагын төсвийн эрх хэмжээ буурсан талаар ихээхэн шүүмжилдэг. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл хийгдсэнээс хойш эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж зэрэг салбарын үйлчилгээг нийлүүлэх, санхүүжүүлэх үүрэг орон нутгийн удирдлагаас салбарын яамдад төвлөрөн шилжсэн нь орон нутгийн төсвийг бууруулах гол шалгаан болсон байна.

Төсөв, хөрөнгө оруулалт яамдад ийнхүү төвлөрсөөр орон нутгийн удирдлага төрийн үйлчилгээтэй холбоотой наад захиан асуудлыг уян хатан шийдэх боломжгүй болжээ. Тухайлбал, аливаа сумын ИТХ, Засаг даргад орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдэх зориулалт бүхий өөрийн бүрэн эрхийн хүрээнд захиран зарцуулах төсөв, хөрөнгө огт алга байна. Орон нутагт үссэн гэнэтийн нөхцөл байдлыг аймаг, сумдад шийдэх хөрөнгө байхгүй, аль нэг сумын эмнэлэг, сургуулийн барилгад засвар хийх, өмчийн ашиглалтыг сайжруулахад шаардагдах хөрөнгийг шийдэх боломжгүй зэрэг олон сөрөг үр дагаврыг тоочиж болно. Хэдийгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 2007 оны өөрчлөлтөөр 500 сая төгрөгөөс доош хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутагт олгож байгаа ч орон нутгийн



Баатархавын Мөнхсоёл

Б.Мөнхсоёл нь ННФ-аас эдийн засгийн асуудлаар хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг хариуцан ажилладаг. Монголын эдийн засаг, бизнесийн хөгжлийн талаарх бодлогын судалгаа, шинжилгээний ажилуудад түлхүү анхаарч ирсний нэг нь төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн санхүүгийн менежментийн асуудал болно. Тэрбээр Тайланд дахь Азийн Технологийн Институттэд бизнесийн удирдлага, Франц дахь Европын Менежментийн Сургуульд шинжлэх ухааны магистр зэрэг тус тус хамгаалж, бизнесийн удирдлага, олон улсын санхүү, эдийн засгийн мэргэжлээр боловсрол зээмшжээ.

ННФ нь бодлого боловсруулах үйл явцад иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих, чанартай судалгаа мэдээллээр бодлого боловсруулагчид, олон нийтийг хангах зорилготой байгууллага юм.



Лхамын Лувсанжамц

ШУТИС-ийн КТМС-ийг бизнесийн удирдлагын баклавр, төрийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссэн. Нутгийн удирдлага, төв ба орон нутгийн төсвийн харилцааны чиглэлээр эрдэм шинжилгээ, бодлогын судалгаа, зөвлөгөө өгөх ажил хийж, судалгааны тайлан, ном, гарын авлага, илтгэл хэвлүүлжээ.

Одоо ЗГХЭГ-ын дэргэдэх, НҮБХХ-ийн “Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр” төслийн Үндэсний менежерээр ажиллаж байна.

бодит хэрэгцээ, шаардлагыг тусгасан, үр ашигтай хөрөнгө оруулалт болж чадахгүй байна. Түүнчлэн төвөөс хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд нутгийн удирдлагын байгууллага, иргэд хяналт тавих боломжгүйгээс шаардлагагүй хөрөнгө оруулалт хийгдэх, хугацаа алдах, чанар муутай гүйцэтгэх асуудал байнга гардаг ажээ. Ийнхүү аливаа тулгамдсан асуудлыг бие даан шийдэх боломжгүй болсноор орон нутгийн засаг захирагааны иргэдийн өмнө хүлээх улс төр, нийгэм, захирагааны хариуцлага суларч байна.

Төрийн үйл хэргийг явуулахад төр, засгийн газар, түүний харьяа яам, агентлаг байгууллага, төрийн албан тушаалтын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанаас илүүтэй ард иргэд, тэр дундаа нутгийн иргэд, тэдний сайн дурын нэгдэл, үйл хэргээ хамжилсан шийдэх ёс, уламжлал хамгаас чухал болохыг дэлхийн олон улс орны жишээнээс харж болно.

Нутгийн өөрөө удирдах ёсонд суурилан орон нутагт иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ил тод, хариуцлагатай болгосныг Баруун Европын улсууд тэр дундаа Швед, Норвеги зэрэг Скандинавын улс орнуудын туршлагаас харж болно.

Иргэдэд төрөөс үзүүлдэг олон төрлийн үйлчилгээг хүргэх, зохион байгуулах, хянах, санхүүжүүлэх үүрэг, хариуцлагыг дан ганц төр, засгийн байгууллагад төвлөрүүлэн гүйцэтгэх бус, эдгээр ажлыг гүйцэтгэх үүрэг, хариуцлага, эрхийг орон нутгийн иргэд, тэдний төлөөлөл болох Нутгийн өөрийн удирдлагын байгууллагад хуулиар олгох нь илүү үр дүнтэй гэсэн үндэслэл буй юм.

Аливаа улс орны төрийн удирдлагын тогтолцоо нь төвлөрсөн эсвэл төвлөрлийг сааруулсан гэх мэтээр ялгагддаг. Мэдээж төр, засгийн оролцох болон Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын хариуцан шийдэх үүрэг функц нь ялгаа заагтай ч зарим үүрэг функцийг хамтран хариуцан шийдэх шаардлага гарах нь ч зайлшгүй билээ. Дан ганц хэт төвлөрсөн төрийн тогтолцоогоор арчилсан нийгмийг зохицуулах боломж огт байдаггүйг энэ замаар хөгжиж ирсэн олон улс орны туршлага бэлхнээ харуулж байна. АНУ, Баруун Европын өндөр хөгжилтэй арчилсан улсууд, социалист системд байсан Зүүн болон Төв Европын улсууд, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан зарим улс орон төрийн төвлөрсөн тогтолцооноос аль хэдийн татгалзаж, төрийн үйлчилгээний хариуцлага, эрх мэдлийг Нутгийн өөрийн удирдлагын байгууллагад шилжүүлэх боллогыг эрчимтэй хэрэгжүүлж байна. Төв Засгийн газар нь шилжүүлэн өгсөн үйлчилгээний талаар тавих хяналтыг хэрэгжүүлж, орон нутгийн өдөр тутмын амьдралд оролцоо шаардлагагүй болдог.

Ингэж төвлөрлийг сааруулснаар нэгдүгээрт, төсвийн бодит хэрэгцээ шаардлагыг төв Засгаас илүүтэй орон нутгийн удирдлага тодорхойлох, хоёрдугаарт, нутгийн иргэдийн ашиг, сонирхлыг мэдрэх уян хатан засаглалтай болох, гуравдугаарт, төсөв, хөрөнгийг нутгийн иргэдийн оролцоотойгоор ил тод, үр ашигтайгаар зарцуулах боломж бүрдэх, дөрөвдүгээрт, иргэдээс Нутгийн өөрийн удирдлагын байгууллагатай тооцох улс төр, захирагааны хариуцлага нэмэгдэх зэрэг олон давуу талыг бий болгодог.

Тухайлбал, орон нутгийн төсөвт байгууллагын албан хаагчдын ажлын үр дүн, идэвхи санаачилгыг нийслэлд байгаа яамдаас илүүтэйгээр орон нутгийн өөрийн удирдлагын байгууллага, захиргаа үнэлж, дүгнэх нь ил тод, шударга, хариуцлагатай байх зарчимд нийцэх юм.

Энэ мэтээр орон нутгийн удирдлагын байгууллагын төрийн үйлчилгээний талаар шийдвэр гаргах, түүнийг санхүүжүүлэх эрх, мэдлийг өгөх нь төвлөрлийг сааруулж буйн илрэл юм.

## ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ ХЭРХЭН СААРУУЛАХ ВЭ?

Төвлөрлөөс олон сөрөг үр дагавар гарч буй хэдий ч төсвийн төвлөрлийг сааруулах асуудлыг оновчтой шийдвэрлэх нь нэлээд түвэгтэй юм. Манай орны хувьд хэд хэдэн онцлог байгаа нь судалгаагаар нотлогдсоор байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, төсвийн орлогын бааз нь хүн ам төвлөрсөн, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ хөгжсөн цөөн тооны аймагт төвлөрсөн байдаг. Эдгээрт Улаанбаатар, Орхон, Дархан хот болон зарим ашигт малтмалын нөөц бүхий аймгууд багтаж байна. Монгол Улсад нийслэл хотоос гадна 5 аймаг өөрийн орлогоороо зарлагаа санхүүжүүлдэг ба бусад аймаг улсын төсвөөс шилжүүлэг авдаг байна. Эдгээр аймгийн хувьд нийт зарлагынхаа 4-60 хувь орчмыг улсын төсвийн шилжүүлгээр санхүүжүүлж байна. Энэ үзүүлэлт баруун таван аймагт хамгийн өндөр буюу 43 хувиас дээш байдаг. Энэ мэтээр Монголын дийлэнх аймаг, сумдын төсвийн өөрийн орлогын эх үүсвэр маш муу байна.

Орон нутгийн төсвийн орлогын дийлэнхийг (90 хувиас дээш) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар зэрэг хэдхэн нэр төрлийн татвараар бүрдүүлж байна. Түүнчлэн хуулиар орон нутгийн татвар хэмээн 12 нэр төрлийн татварыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт оноосон хэдий ч эдгээр татварын хувь хэмжээг тогтоох, ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт хийх эрх мэдлийг нь тухайн орон нутгийн Хурал бус УИХ, Засгийн газар эдэлдэг байна. Бодит амьдрал дээр орон нутгийн татвар сонгодог утгаараа алга байна гэж хэлж болох юм. Ингэж орон нутгийн татварын эрх мэдлийг хумьсан нь байгалийн нөөц, баялгаа зохицой ашиглах, онцлог байдал, давуу талдаа суурилсан төсөв, татварын бодлого баримтлах, орлогын тогтвортой эх үүсвэртэй болж, түүнийг хураах, ашиглах чадавхи, тогтолцоо бий болоход сөрөг нөлөө үзүүлж байна.

*Хоёрдугаарт*, Ихэнх аймаг, ялангуяа сумдад дэд бүтэц муу хөгжсөн, үйлдвэрлэл, худалдаа хөгжих боломж муу, хүн ам маш цөөн, тархай, бутархай суурьшсан, газар нутаг томтой зэрэг заяамал нөхцөл байдал нь цаашид ч орлогын тогтвортой эх үүсвэр бий болоход саад учруулах юм.

*Гуравдугаарт*, Монгол Улс нь нэгдмэл засагтай улсын хувьд төрийн үйлчилгээний стандартыг орон даяар жигд мөрдүүлэхийг зорьдог. Энэ үүднээс аймгуудын нэг хүнд ногдох төсвийн зарлагын хэт ялгааг үүсгэхгүй байх төсвийн тэнцвэрийг хангах бодлогыг цаашид барих хэрэгтэй. Иймээс аймаг хоорондын орлогын ялгааг бий

болгоход хүчтэй нөлөөлдөг ашигт малтмалын нөөцийн төлбөр, хүн амын орлогын татварыг дахин хуваарилах шаардлага зайлшгүй гарч байна.

*Дөрөвдүгээрт*, аймаг, сумдын хувьд жил бүр төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийн хэмжээгээ урьдчилан тооцох, тодорхойлох боломжгүй байна. Учир нь өнөөгийн дэмжлэгийн систем нь тухайн засаг захиргааны нэгжийн төсвийн өөрийн орлогын чадавхи, зарлагад нөлөөлөх хүн амын тоо, төрийн үйлчилгээний хэрэглэгчдийн тоо, газар нутгийн алслалт, засаг захиргааны нэгжийн тоо зэрэг объектив үзүүлэлтэд суурilan олгогдоггүй зөвхөн зөрүүг санхүүжүүлэх зарчмаар жил бүр хэлэлцээр хийх байдлаар явагддаг. Дэмжлэгийг зөвхөн орон нутгийн төсвийн урсгал зарлага, орлогын зөрүүг нөхөн байдлаар, тодорхой зарчим, түүнийг хадгалсан томъёонд суурilж олгодоггүй байна.

*Тавдугаарт*, өнөөгийн орон нутгийн төсөв нь зөвхөн аймаг, сумдын захиргааны урсгал зардал буюу захиргааны албан хаагчдын цалинд дийлэнх хэсэг нь зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь Засаг даргын тамгын газрын байрны ашиглалтын зардал (дулаан, цахилгаан гм) төдийд дөнгөж хүрэлцэхүйц байна. Аймаг сумд хуулиар хариуцсан чиг үүргээ<sup>1</sup> хангалттай биелүүлэх хөрөнгө оруулалтын болоод урсгал зардал маш хомс байна. Ялангуяа орон нутгийнхаа хөгжилд зориулан хэнээс ч хамааралгүй бие даан захирлан, зарцуулах хөрөнгийн эх үүсвэр огт алга.

Баруун болон зүүн Европын ардчилсан улс орнуудад орон нутгийн төсвийг нутгийн удирдлагын байгууллага нь хэнээс ч үл хамааран өөрөө мэдэж, захирлан зарцуулах хөрөнгө гэж үздэг. Тухайлбал, 1985 онд Европын холбооны гишүүн улсууд нэгдэн орсон "Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти" –ийн 9-р хэсгийн 1-р зүйлд "Нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлэхд хангалттай хэмжээний хөрөнгөтэй байх ба үүнийгээ бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй байна." хэмээн заасан байдаг. Энэ эрхийг нь Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулсан байхыг гишүүн улсуудад үүрэг болгосон байдаг.

Ихэнх улс орнуудад орон нутгийн төсөв нь улсын төсвөөс тусдаа орлого, зарлагатай байж тусгай хууль, эрх зүйгээр баталгаажсан байдаг бол манайд улсын төсвийн салшгүй нэг бүрдэл хэсэг мэтээр ташаа ойлгож иржээ.

## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Дээр дурдсан байдлыг харгалzan нутгийн удирдлагын төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төсвийн төвлөрлийг сааруулах зорилгоор дараах бодлогыг хэрэгжүүлэхийг санал болгож байна.

*Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, улсын ба орон нутгийн төсвийн харилцааг оновчтой болгохын тулд төрийн*

захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын чиг үүргийн ялгаа заагийг бий болгох, орон нутгийн татварын эрх, хэмжээг нэмэгдүүлэх, татварын хуваарилалтыг шинэчлэх, санхүүгийн дэмжлэгийн (шилжүүлэг) шинэ механизмыг бий болгох зайлшгүй шаардлагатай.

## БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Уг бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд дараах шинэчлэлийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

**1. Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын чиг үүргийн ялгаа заагийг бий болгох хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуулиар оноосон чиг үүргийн ерөнхий заагийг тогтоож аль болох давхардуулан оноохгүй байх.** Тухайлбал аймаг, нийслэл нь нэгдсэн эмнэлэг, эрүүл мэнд, соёлын нэгдсэн байгууллага, зам, тээвэр, орон нутгийн дэд бүтэц зэрэг чиг үүргийг хариуцдаг байхад сум, дүүрэг нь бага, дунд боловсрол, хүүхдийн цэцэрлэг, хог хаягдал, ундны усан хангамж, гудамжны гэрэлтүүлэг, хот тохижуулахтай холбоотой чиг үүргийг хариуцдаг байхаар хуульчилж болох юм.

Засаг захиргааны нэгж бүр эдгээр чиг үүрэг тус бүртээ ногдох төсвөө авч дээд нэгжээсээ үл хамааран захирлан зарцуулдаг тогтолцоог бий болгох.

Төв Засгийн газраас үйлчилгээ бүр дээр үр дүнгийн үзүүлэлтүүдийн стандарт, зарлагын зөвшөөрөгдхөө доод хэмжээг тодорхойлж орон нутгийн үйлчилгээнд хяналт, мониторинг хийж ажиллах.

Цаашид нийслэлээс гадна бусад хотыг засаг захиргааны нэгжийн статустай болгон хуульчилж, хариуцах чиг үүрэг, төсвийн зарчмыг хөдөө аймгаас ялгавартай авч үзэх.

**2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын татварын эрх хэмжээг өргөтгөх, одоогийн орон нутгийн татварын хуваарилалтад зарим шинэчлэл хийх хүрээнд орон нутгийн татварын хувь хэмжээг тогтоох, татвараас хөнгөлөх чөлөөлөх эрхийг Нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өгөх.** Ингэхдээ татварын хувь хэмжээний доод, дээд хязгаарыг УИХ-аас батлах зарчмыг баримтлах. Орон нутаг үзүүлсэн үйлчилгээнийхээ хураамжийг бие даан тогтоох эрх мэдлийг олгох.

Бус нутаг хоорондын төсвийн тэнцвэрийг алдагдуулах татвар болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүн амын орлогын албан татвар зэргийн орлогыг нэг мөсөн эсвэл хувьчлан авч орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэн аймаг, сумдад дахин хуваарилах.

**3. Санхүүгийн дэмжлэгийг хуваарилах механизмыг төсвийн тэнцвэрийг хангах зорилгоор шинэчлэх**

Ихэнх засаг захиргааны нэгжийн орлогын гол эх үүсвэр нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг байх нь тодорхой болж байна.

Жил бүр төсвийн хуулийн дагуу орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан байгуулагдах ба сангийн эх үүсвэр нь 1/ улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 2/Хуваалцах татварын орлого - хүн амын орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос орон

<sup>1</sup> Одоогийн хууль, эрх зүйн зохицуулалтаар (2002 оноос хойш) боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хalamжийн зэрэг салбарын чиг үүргийг орон нутаг бус Засгийн газрын яамдууд хариуцаж, санхүүжүүлж, нийлүүлж байна. Эдгэрээрс гадна хуулиар аймаг, нийслэл, сум, дүүрэгт оногдсон гал түймэртэй тэмцэх, нийтийн ариун цэврийг ханггулах, хүн амыг ундны усаар хангах, хог хаягдлыг зайлшуулах, хотын нийтийн үйлчилгээг хангах, гудамж талбайг гэрэлтүүлэх зэрэг чиг үүрэгт үндсэндээ төсөв, хөрөнгө хүрэлцэггүй.

нутагт хуваарилах хэсэг<sup>2</sup> (Хэрэв НӨАТ-ыг орон нутагтай хуваалцахаар шийдвэрлэвэл уг татварын орлогын орон нутагт хамаарах хэсэг) зэргээс бүрдэх.

Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дунд хугацаанд жил бүр УИХ-аас макро эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан хуульчилж болно.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрсөн хөрөнгийг аймаг, сумдад хуваарилахдаа томъёонд сууринла.

Аймаг, сумд олгох төсөв нь урсгал болон хөрөнгө оруулалтын гэсэн 2 хэсэгт хуваагдана.

1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох урсгал шилжүүлгийг тооцдоо төсвийн тэнцвэрийг хангах зорилго бүхий дараах томъёонд үндэслэнэ.

Хуваарилалтын томъёо нь аймаг, сумын өөрийн орлогын чадавхи, тухайн төрийн үйлчилгээний стандарт зарлагад сууринлас байна.

### G=EEx+Ex (1)

Үүнд: **EEx** – Нэг хүн амд ногдох стандарт зардалд сууринж тооцсон дэмжлэгийн хэмжээ

**Ex** - Нэг хүн амд ногдох өөрийн орлогын чадавхид сууринж тооцсон дэмжлэгийн хэмжээ

А. Тухайн аймагт олгох урсгал шилжүүлгийг тооцдоо уг аймаг аливаа үйлчилгээг (зарлагыг) нийлүүлэхэд гарах нэг хүнд ногдох стандарт зардал болон түүний үндэсний дундаж үзүүлэлтийг харгалзан үзэх шаардлагатай. Дараах томъёогоор илэрхийлж болно.

$$EE_x^i = (POP)_x \{ (PCSE) - \frac{i}{x} (PCSE) \}_{na}^i \quad (2)$$

Үүнд :

<b>EE<sub>x</sub><sup>i</sup></b>	i - Үйлчилгээнд тухайн аймгийн авах эсвэл хасагдуулах тусламжийн хэмжээ
<b>(POP)<sub>x</sub></b>	Аймгийн хүн амын тоо
<b>(PCSE)<sub>x</sub><sup>i</sup></b>	i - Үйлчилгээний аймгийн нэг хүнд ногдох стандарт зардал
<b>(PCSE)<sub>na</sub><sup>i</sup></b>	i - Үйлчилгээний нэг хүнд ногдох улсын дундаж стандарт зардал

Төрийн үйлчилгээ тус бүр дээр нэг хүнд ногдох стандарт зардлыг тооцон, улсын дундаж зардалтай харьцуулах замаар дэмжлэгийн энэ хэсгийг тооцно.

Б. Орон нутагт олгох урсгал шилжүүлгийг тооцод ашиглах дараагийн хүчин зүйл нь тухайн засаг захиргааны нэгжийн өөрийн орлогын чадавхи юм. Шилжүүлгийн энэ хэсгийг дараах томъёогоор тооцно.

$$E_x^i = (POP)_x \{ [(PCTB) \times \frac{i}{na} t_{na}^i] - [(PCTB) \times \frac{i}{x} t_{na}^i] \} \quad (3)$$

<b>(POP)<sub>x</sub></b>	Аймгийн хүн амын тоо
<b>(PCTB)<sub>na</sub><sup>i</sup></b>	Нэг хүнд ногдох i –р татварын орлогын баазын улсын дундаж хэмжээ
<b>(PCTB)<sub>x</sub><sup>i</sup></b>	Аймгийн нэг хүнд ногдох i –р татварын орлогын баазын хэмжээ
<b>t<sub>na</sub><sup>i</sup></b>	i –р татварын хувь хэмжээний улсын дундаж утга

<sup>2</sup> Одоогийн хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 70 хувь нь улсын , 20 хувь нь аймгийн, 10 хувь нь сумын төсөвт орохоор заасан байна.

Орон нутгийн өөрийн орлогын төрөл тус бүр дээр дээрх томъёогоор тооцож, гарсан үр дүнгүүдийг нэмэх замаар тухайн аймгийн авах, эсвэл хасагдуулах шилжүүлгийн хэмжээг тооцно.

Эцэст нь тухайн орон нутгийн стандарт зарлага, өөрийн орлогын чадавхи тус бүрт харгалзах томъёогоор тооцсон үр дүнгүүдийг нэмж уг аймагт олгох урсгал шилжүүлгийг тооцно. (томъёо 1)

Төвлөрсөн сангаас орон нутагт олгох урсгал дэмжлэгийг а/аймагт шууд олгоод аймгаас дээрх зарчмаар сумдад олгох, б/сангаас шууд аймаг, сум тус бүрт олгох хоёр хувилбарын аль нэгээр нь шийдэж болох юм.

2. Орон нутгийн хөгжлийн төвлөрсөн сангаас орон нутагт олгох урсгал шилжүүлгийг хасаад үлдсэн хэсэг нь хөрөнгө оруулалтын шилжүүлэгт зарцуулагдах юм.

Хөрөнгө оруулалтын шилжүүлгийг аймаг, сумдад олгоходоо хүн амын тоо, ядуурал, газар нутгийн хэмжээ зэрэг үзүүлэлтэд үндэслэн шийдвэрлэж болох юм.

Дээр дурдсан зарчим, томъёоны үндсэн агуулгыг төсвийн хуулийн орон нутгийн удирдлагын бүлэгт хуульчлан тусгах шаардлагатай. Ингэснээр орон нутгийн төсвийг УИХ-аар жил бүр нарийвчлан хэлэлцэх шаардлагагүй болох ба аймаг, нийслэл, сум, дүүрэг нь урьчилан тодорхойлох боломжтой, ижил тэнцүү, бие даан шийдэх эрх бүхий төсөвтэй болох юм.

Шилжүүлэг хуваарилах томъёотой холбоотой нарийвчилсан тооцоо хийх журмыг Засгийн газар баталж, Сангийн яам мөрдүүлэн ажиллах боломжтой.

Энд санал болгож буй зөвлөмж, арга замыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд Төсвийн хуулийн төсөлд тусгах, хоёрт, Монгол Улсын Үндсэн хууль, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон салбарын хуулиудад зарим нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарна.

### Зураг2. Орон нутгийн хөгжлийн төвлөрсөн сангийн орлого, зарлагын бүдүүвч

